

ДУРЬДАТГАЛ, СЭТГЭГДЭЛ

АНУ-Д ОДСОН НЬ

Үргэлжлэл

Ш. Сандаг

Вашингтонд байх хугацаанд бидэнд Конгрессын номын санг үзүүлж сонирхуулсан нь сайхан сэтгэгдэл төрүүлээ.

АНУ-ын Үндэсний энэхүү номын сан 1800 онд анх байгуулагдсан цагаас хойш ихэд ч өргөжин баяжуулагдаж, одоогийн ерөнхийлөгч нь Джеймс Веллингтон ажээ. Өндөр нуруутай, эелдэг зан төрхтэй энэ хүн Москва орохоор одсон АНУ-ын ерөнхийлөгч Рейган тэргүүтэй төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орсон бөгөөд маргааш хойноос нь явж нийлэх учраа бидэнд хэлж, тусгай цаг гарган найр тавин уулзсан билээ. Дж. Веллингтон танай Монголоос ирэх ном, зохиол, сонин, хэвлэл их л дутмаг байгааг тэмдэглэж, тус номын сангийн Монголын фондыг арвижуулан баяжуулах санаатай гэв. Тэгэхдээ монгол хэл мэдэх хүн байхгүй тул, байгаа өчүүхэн фондыг эмхлэх хэцүү байна, танайхаас тусгай мэргэжилтэн урьж, түр хугацаагаар ажиллуулж болох юм гэж Веллингтон хэлэв.

Энэ номын сан дэлхийн дээр бараг хамгийн том нь бөгөөд газрын бөмбөрцгийн өнцөг булан, улс орон бүрээс янз бүрийн сонин хэвлэл, ном зохиол, баримт материал, архивын ховор бичиг сэлт цуглуулан нандигнан хадгалсаныг үзэхэд үнэнхүү гайхмаар. Тэр үеэр энэхүү номын санд өргөтгөл хийж байлаа. Фонд нь улам өргөжих нь ээ. Олон уншигчдыг үйлчлэх нь гайхалтай түргэн шуурхайг хэлэх юун. Энд 5000 хүн ажилладаг. Манай Монголоос юу байдаг бол гэж сонирхоход хамгийн цөөхөн фондтой ажээ. Хятадын фондын дэргэд байрлуулжээ. Сонирхвол, «Намын амьдрал» сэтгүүл, «Үнэн» сонин хожуу боловч алдаг оног хүрч очдог бололтой. Манай ном зохиол бараг байхгүй, гагцхүү урьд хэвлэгдсэн «Үүлэн Бор», «Арван таван наст капитан» л харагдах жишээтэй. Сүүлийн үеийн манай ном зохиолоос мэр сэр байдаг бололтой. Би өөрийн бичсэн зохиолоос юу байдгийг компьютерээр хайлгахад агшин зуур дэлгэцнээ «Татаро Монголы в Азии и Европе», Москва, 1977, хамтын бүтээлийн зохиогч гэж хариу өгсөн. Ингэж, хамтын бүтээлийн зохиогчдыг ч хүртэл компьютер ялган салгаж, ой тойндоо хадгалдаг аж. Хуучин янзаар, каталог эрх хайх, эмэрч үзэж цаг алдах хэрэггүй сайхан болжээ. Компьютерын эрин үе Конгрессын номын санд нэвтэрсэн нь энэ аж. Харин миний дангаараа бичсэн эрдэм шинжилгээний зарим зохиолууд байхгүй байсан. Тухайлбал, «Монголын улс төрийн гадаад харилцаа» (1850—1919) монографийн 1-р дэвтэрийг (Улаанбаатар, 1971) тэрхүү номын санд авсангүй болохоор компьютерт тусгагдсангүй бизээ.

АНУ-ын Конгрессын номын санд монголын фонд ийм чамламаар байгааг улсын нийтийн номын сангийн захирал Цагаачид дамжуулан хэлэв.

* Түүрүүч нь «ДДСА» № 2 (19) сэтгүүл, 1988 онд нийтлэгдсэн, Шагдарын Сандаг. Түүхийн ухааны доктор, ДДСХ-ийн захирал

Ер нь АНУ, БНМАУ-ын хоёр томоохон номын сангийн хооронд ном хэвлэл солилцох явдлыг өргөжүүлэх цаг нэгэнт болсон гэсэн сэтгэгдэл өвөрлөн бид тэндээс гарч явлаа.

Вашингтонд Үндэсний шинжлэх ухааны Академи байдаг. 1863 онд АНУ-ын ерөнхийлөгч Авраам Линкольны зарлигаар байгуулагджээ. Энд биднийг тус академийн гадаад харилцааны хэлтсийн эрхлэгч Виктор Рабинович, БНХАУ-тай шинжлэх ухааны хэлхээ холбоо тогтоох хорооны захирал Мария Буллок нар угтан авч ярилцав.

Төлөөлөгчдийн тэргүүн Н. Содном нарны гэрлийг ашиглан цахилгаан гаргах болон биотехнологийн талаар Америкт ямар шинэхэн ололт амжилт байгааг сонирхон асуусан билээ.

Хэдэн жилийн өмнө Өрнөдөд нефтийн хямрал гарахад нарны гэрлийг ашиглан цахилгаан гаргах явдлыг Америкт үйлдвэрийн үндсэн дээр тавьж хөгжүүлж байжээ. Харин ойрноос нефтийн хямрал намжиж, энэхүү «хар алтны» үнэ бууж ирэхэд Америкт нарны илч ашиглах явдалд анхаарал суларсан, гэвч энэ талаар үзүүлэх юм багагүй байна гэж америкийн академид бидэнд ярьж байлаа.

Мари Буллок хатагтай Дорнодахиныг судалдаг болохоороо ч юм уу, манай Монгол орныг их л сонирхох ажээ. Монголын газар нутгийн байдал, цаг агаар, хэрхэн өөрчлөн байгуулалт явагдаж байгаа зэргийг асууж лавлана. Энэ хатагтай найр тавин, биднийг япон загварын өөрийн судлын тэргээр Вашингтон хотоо үзүүлэн, Академийн шинээр барьж буй барилга дээр аваачиж сонирхууллаа. Тэнд бид аугаа их эрдэмтэн физикч А. Эйнштейний суугаа асар том зэсэн хөшөө байхыг үзэж сонирхов. Герман гаралтай америк энэ эрдэмтэн (1879— 1955) харьцангуйн онол гаргаж, онолын физикт эргэлт хийсэн ажээ. Түүний хөшөө тавьсан тавцаны хананд үнэнийг эрэлхийлэх эрх бол үнэн болох нь батлагдсан зүйлээсээ нуухгүй хэлж байх үүрэг бас оногдуулна гэсэн утгатай үгийг нь англи үсгээр хадсаныг эргэцүүлэн бодвол эрдэм номын шимийг хүн төрөлхтөнд түгээж байхын учир холбогдлыг сануулсан байна. Үнэндээ эрдэмээ бусдаас нугаад байвал шинжлэх ухаан яахин хөгжих вэ? Ардчилал байдаг юм бол юуны түрүүнд шинжлэх ухааны талбарт байх ёстой. Ардчилал, эрх чөлөөг хүндэлсэн газар шинжлэх ухаан дэлгэрэн хөгжих жамтай аж.

Сэтгүүлийн өмнөх дугаарт эхлэн бичсэн замын тэмдэглэлээс нэгэн зүйлийг тодотгохыг хүснэ.

Манай төлөөлөгчид АНУ-д байх үеэр БНМАУ-ын Шинжлэх Ухааны Академи, эрдэм шинжилгээний нийгэмлэгүүдийн Америкийн Зөвлөлийн хооронд 1988— 1990 онд харилцан эрдэмтэд солилцох тухай протокол хэлэлцээр байгуулагдсан билээ. Энэ хэлэлцээрт монголын талаас БНМАУ-ын ШУА-ийн ерөнхийлөгч Н. Содном, америкийн талаас дээрх Зөвлөлийн ерөнхийлөгч, доктор Стэнли Катц нар 1988 оны 5-р сарын 23-нд Нью-Йорк хотноо гарын үсэг зурлаа. Харилцан хиролцсон ёсоор хоёр тал эрдэмтэд солилцох болзолыг жил бүр 20 сар хүнээр тогтоов. Өөрөөр хэлбэл, нэг нэг хүн солилцвол 20 сараар, 4 хүн солилцвол тус бүр 5 сараар явуулж байх жишээтэй. Эсхүл 2 хүн явуулбал тус бүр 10 сар байх мэт.

Ингэж ардын хувьсгалын анхны жилээс тэрч байтугай түүнээс өмнө бүр Богд хаант Монгол улсын үеэс АНУ-тай хэвийн найрамдалт харилцаа, худалдаа-эдийн засгийн хэлхээ холбоо тогтоох гэсэн эрмэлзлэл ийнхүү 70-аад жилийн дараа сая биелэлээ олсон хэрэг бо-

жээ. Үүнд ерөнхийд нь хэлбэл хоёр талын санаачлага, идэвхтэй үйл ажиллагаа дутсанаас юуны өмнө ийм болсон биз ээ. Нөгөө талаар, АНУ-ын эрх баригчид сүүлийн үе хүртэл манай БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хүлээн зөвшөөрөхгүй, дайсагнаж байсныг хэлэхийн хамт БНМАУ ч Чойбалсанг тахин шүтэж байсан хийгээд түүний гай уршгаар гадаад ертөнцөөс тасархай байсны харгаа болохыг тэмдэглэвэл зохино. Гэвч ийм байдал нэгэнт улиран өнгөрч, манай хоёр орны хооронд шинэ нөхцөл бий боллоо.

Одоо БНМАУ, АНУ харилцан дипломат харилцаа тогтоож, элчин сайд солилцож, хэвийн найрамдалт харилцааг өргөтгөж, хамтын ажиллагааг өрнүүлэхийн төлөө тодорхой алхам хийж байна.

Үүний нэг баримт нь дээр дурдсан хэлэлцээр мөн. Монгол, Америкийн хооронд эрдэмтэд солилцох тухай байгуулсан энэ хэлэлцээр тус хоёр орон шинжлэх ухаан, техникийн талбарт хамтран ажиллаж явдалд эхлэлт тавьж байгаа учир түүхэн ач холбогдолтой болжуу.

Гараа сайн бол бариа сайн гэдэгчилэн, дээрх хэлэлцээр монгол, америкийн газар шороон дээр хавар зуны урин дулаан цаг эхлах байх үеэр хоёр тал бие биеэ харилцан ойлголцсоны үндсэн дээр саад бэрхшээлгүй байгуулагдсан нь БНМАУ, АНУ-ын хооронд найрамдалт харилцаа эдийн засаг, соёл, улс төрийн салбарт энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын дагуу өрнөн хөгжихийн бэлэг дэмбэрэл болсон гэж найдна.

Уул хэлэлцээр байгуулахад бид манай талаас шалтгаалах нэг бэрхшээлтэй тулгарсныг энд эс тэмдэглэвэл үнэнгүйд хүрэх билээ. Бид Америкт байхдаа хэлэлцээ хийх үеэр өөрийн сангийн яамны гох дэгээнд өртөгдөж, нэг чухал асуудлыг нааштай шийдвэрлэж чадсангүй. Юу гэвэл, хоёр тал харилцан солилцох эрдэмтэддээ чухам зардал хэдээр олгох асуудал ярилцахад америкийн тал та нарын саналаар болсугай, өдөрт 90-д ч доллар байж болох юм гэхэд манай тал манай Сангийн яамнаас социалист орнуудтай тогтоосон журмыг баримтлахаас өөр аргагүй хясагдаж, өдөрт 59 төгрөгтэй тэнцүүлэн бодъё гэвэл, нөгөө тал арай бага биш үү хэмээн зөвшөөрч, тэр ёсоор хэлэлцээрт оруулан батлав. Өөрөөр хэлбэл, Америкаас манайд ирэх эрдэмтэд өдөрт 59 төгрөг, Монголоос Америкт очих эрдэмтэд 20 долларын зардалтай тус тус байх жишээтэй. Америкт очих манай эрдэмтэд зардал мөнгөөр нэлээд дутмаг байх болов уу даа гэж бодох юм. Жирийн нэг зочид буудалд өглөөний хоол 20 доллараар тогтохгүй боловч, хямд төсөр гуанзуудаар хоолловол хүрэлцэх мэт. Долларын ханш АНУ-даа төдий л дээгүүр бус ажээ. Харин Монголд ирэх америкийн эрдэмтэд өдөрт 59 төгрөг авах нь элбэг хүрэлцээтэйгээс гадна тэд чөлөөт валют ихтэй явдаг болохоор бүр ч хангалттай ажээ.

Манайд хоол ундаа, бараа таваарын зүйлс хямд байна.

Дашрамд тэмдэглэхэд тус улс капиталист улсуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа өрнүүлэх чиг баримжаатай байгаа тул янз бүрийн мэргэжлийн хүмүүс нааш цааш явах нь ихсэх болохоор чөлөөт валютын орнуудад одох Монгол иргэдийнхээ зардал төсвийг эргэн эрхбиш бодууштай байна. Ер нь манай санхүүгийн систем уян налархай, хурдан шуурхай байвал болохгүй тал байна уу?

АНУ-д байх хугацаанд биднийг Вашингтонд Төрийн департамент хүлээн авсан билээ. Тус департаментийн Хятад, Монголын хэрэг эрхлэх хэлтсийн дарга бөгөөд манай БНМАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Ричард Уильямс манай төлөөлөгчдийг хүлээн авч найрсгаар ярилцав. Элчин сайд бидний амар мэндийг асууж, Америкад ирсэн хэрэг бүтэмжтэй юу, туслуулж барих юу байна гээд АНУ, БНМАУ хоёр шинжлэх ухааны талбарт ингэж хэлэлцээр байгуулж, харилцан эрдэмтэд солилцох явдал тус хоёр орны хооронд янз бүрийн салбарт хамтын ажиллагаа өрнүүлж, найрамдал, ойлголцох итгэлцэх явдлыг бэхжүүлэхэд чухал болохыг цохон тэмдэглэв. Элчин сайд Р. Уильямс цааш нь хэлэхдээ би Монголд суугаа элчний хувьд тийшээ түр очдог, ер нь ирэх жилээс АНУ-ын Элчин сайдын яам танайд байнгад суух болох байх аа, гагцхүү одоогоор байрны асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй болж байна гэж өгүүлж билээ.

Бид Вашингтонд ЮСИА буюу АНУ-ын мэдээллийн агентлагт очиход тэр байгууллагын шугамаар гадаад орнуудтай соёлын талын олон төрлийн арга хэмжээ авах, оюутан солилцох зэрэгт Фулбрайтын фондын программын дагуу санхүүжигддэг гэж Монголтой ЗХУ ба социалист бусад орны адилаар оюутан солилцож болох тухай яриу.

Америкийн газар шороон дээр хэдэн өдрийг өнгөрүүлэх завсраа очсон газар, уулзсан хүн, үзсэн харснаа энэ замын тэмдэглэлд бүгдийг хамрахын аргагүй тул хотын байдал, дэлгүүр худалдаа, үйлчилгээ тэргүүтнээс цухас дурьдмаар байх юм.

Миний өмнө өгүүлснээр Нью-Йорк хот дэлхийд хамгийн том хот, тэнгэр баганадсан хамгийн өндөр сүрлэг барилга байшинтай ажээ.

Бид Нью-Йорк дахь Эмпайр-Стейт-Билдинг хэмээх асар өндөр 102 давхар байшинд орж үзлээ. Үүний орой дээрээс Нью-Йорк хот гарын алган дээр байгаа юм шиг тодхон харагдах бөгөөд нүдний хараа тэнгэр цэлмэг өдөр эргэн тойрон 80 милийн зайнд тусна. Зүг зүгт харахаар дуран авай зоожээ. Хэрэв лифтээр эс гарвал, оройд нь хүртэл 1860 шатаар алхана. 6500 цонхтой бөгөөд автоматаар байнга угаагдаж байдаг гэхчилэн олон зүйлийг хэлж болох байна. Эмпайр Стейт-Билдингийн орой дээрээс алсын бараа харахад юутай сайхан. Нью-Йорк хотын шавааралдсан олон сүрлэг барилга байшингууд цэнхэртэн ягаарах манан буданд хөглөрөн харагдана. Дорогш харваас гудамжаар яваа машинууд хүүхдийн тоглоом аятай ийш тийш сүлжилдэн давхина. Хүмүүс ч бас хүүхэлдэй мэт алхацгаана.

Уран барилгын гайхамшиг энэхүү Эмпайр-Стейт-Билдинг 1931 онд барьж дуусгаснаас хойш өндрийн рекордоо алдаагүй явсаар эдүгээ хүрсэн боловч, 1974 оноос Нью-Йоркад Дэлхийн худалдааны төв ихэр хоёр 210 давхар байшин босгосон нь түүнээс давж гарчээ. Гэхдээ Эмпайр-Стейт-Билдинг сүр сүлдээ өчүүхэн ч алдсангүй, өндөр барилгуудын эхлэл тавьсан гэсэн юм шиг жавхлантай хэвээр ажээ.

Бид Эмпайр-Стейт-Билдингийн оройгоос дэлхийн худалдааны төв ихэр хоёрыг тэртээд сүндэрлэн байхыг харж, гагцхүү завгүй тул очиж үзсэнгүйдээ сэтгэл дундуур байлаа. Гэвч өндөр барилгуудаас нэгийг үзвэл болох боловч, хэрэв завтайсан бол бусдыг сонирхвол болохгүй юм юу байх билээ.

Нью-Йоркыг бодвол Вашингтон их л цэвэрхэн авсаархан хот ажээ. Гэхдээ Нью-Йорк ч цэвэрхэн хот. АНУ-ын энэхүү нийслэлд за-

саг захиргаа төвлөрчээ. АНУ-ын дотоод гадаад бодлого боловсруулдаг газар-Цагаан байшин, Конгрессын байшин зэрэг энд цайран харагдах юм. Энд чимээ шуугиан харьцангуй бага, хүний хөл гайгүй.

Принстон бол багахан хот, хөвчин ой, ногоон зүлгэнд умбах мэт. Энд алдарт Принстоны их сургууль байдаг. Бид Нью-Йоркоос Вашингтон очихдоо төмөр замаар явж, буцахдаа автобусаар Принстонгоор дайрсан юм.

Принстоны ийм нам гүм, олон шувуу жиргэсэн ой дотор их сургуулийн оюутны байр, эрдэмтэн профессоруудын орон сууц байдаг ажээ. Энд алдарт эрдэмтэн А. Эйнштейний сууж байсан түүхт байшингийн дэргэдүүр гарлаа. Бас Сталины охин Светлана энд түр сууж байсан гэж бидэнд сонирхуулан ярьж байлаа.

Принстоны энэ сайхан байгальд шинжлэх ухааны нийгэмлэгүүдийн Америкийн Зөвлөлийн ерөнхийлөгч С. Катц, АЙРЕКС-ын захирал А. Кассоф, мөн орлогч захирал бөгөөд биднийг Америкт байхад анхаарал тавин үйлчилгээг удирдаж байсан Д. С. Матушевски нарын орон сууцны байшин байдаг. Орон сууцны байшинг манайх мэт ойлгож болохгүй, тус тусдаа Нэг-Хоёр давхар авсаархан цэвэрхэн орд харш юм байна. Харин хашаагүй байх юм. Тэнд ЗХУ-ын Дорнодахины хүрээлэнгийн хэсэг эрдэмтэдтэй дайралдаж, мэнд усаа асуулцаж, Америкт уулзсаны ерөөл дэвшүүлж байлаа. Матушевски гуай Монгол, Зөвлөлтийн хэсэг нөхөд биднийг хүлээн авч дайллаа. Байшингийн гадна, нэр үл мэдэх нарсархуу модны ёроолд урт ширээ засч идээ ундаа, архи дарс өрсөн байлаа. Энэ нөхөрсөг хүлээн авалт дээр ерөнхийлөгч С. Катц гэргийн хамт, Матушевски гэргийн хамт байсан. А. Кассоф гуай ажлаар Лондон явсан тул гэргий нь байсан. Бас Принстоны их сургуулиас хэдэн профессор багш нарыг урьж бидэнтэй танилцууллаа. Принстоны их сургуульд гадаад олон орноос эрдэмтдийг 2-3 жилээр урин ирүүлж, лекц уншуулдаг сайхан заншилтай ажээ. Ийм хүмүүсийг визитинг профессор гэж нэрлэдэг тусгай хэллэг ч бий. Уригдан ирж ном зааж байгаа гэсэн үг. Уригдсан эрдэмтэн гэсэн ч болно. Ийм нэг уригдсан эрдэмтэн Вьетнам профессоротой бид уулзаж ярилцсан юм. Үүнээс ургуулан бодвоос, манай Монголоос ч Монголын эрт эдүүгээгийн түүх унших профессор ч Принстоны их сургуульд очиж болохгүй гэх газаргүй мэт. Гагцхүү, хоёр талын санаачилга хэрэгтэй ажээ. Ер нь Принстоны их сургууль энэ мэтээр олон орны эрдэмтдийн хэлхээ холбоог тогтоож, баяжуулж байдаг газар мөн ажээ. Принстоны их сургуулийн профессор Алсэн над энэ хүлээн авалтан дээр «Монголын империализм» гэсэн өөрийн нэг бүтээлээ бэлэглэсэн нь Мөнх хааны үеийн монголчуудын гадагш довтолсон тухай өгүүлжээ. Энэ номын тухай шүүмж тус сэтгүүлийн дараагийн дугаарт хэвлэгдэн гарах болно. Ингэх нь гадаад олон орны эрдэмтдийн туршлага мэдлэгийг сайтар ашиглахаас гадна, тэдний харилцан ойлголцох, хамтран ажиллахад их тустай ажээ. Ийм туршлагыг анхаарууштай зүйл хэмээвэл болно.

АНУ-д албан хэргээр одсон бид даанч цөхөн хоносныг хэлэх үү, завгүйг хэлэх үү, чөлөөтэй явж юм сонирхож чадсангүй. Ганц нэг дэлгүүрээр шагайж үзвэл бараа таваар элбэг дэлбэгийг зүйрлүүлбэл хүний хар нүднээс бусад нь байх жишээтэй. Гагцхүү хувцас хунар манайхаас үнэтэй бололтой. Нэг зүйл анхаарал татсан нь америкийн

дэлгүүр хоршоогоор бараа таваар элбэгээс ч юм уу, хүн ялаа батгана адил багширан оочирлох дугаарлах явдал ерөөс гардаггүй. Иймээс дэлгүүр дотор агаар цэнгэг, шороо тоос дарахгүй байна. Дэлгүүрүүд нь ч зайтай, чөлөөтэй байх ажээ. Харин талбай бага зарим дэлгүүрт бараа таваарыг ханаар зай завсаргүй жигдлэн өрсөн нь нарийн гудам гаргасан мэт. Хүнсний дэлгүүрт нь жилийн дөрвөн улиралд хүнсний ногоо, алим жимс ерөөс тасрах гэж байхгүй. Газрын бөмбөрцгийн хаа л бол хаанаас авчирж зарах тул худалдан авагчид үргэлж шинэ ногоо, шинэ жимсээр хангалттай байдаг байна.

Сайн хүн явснаа, муу хүн идсэнээ гэдэг үг байдгийг үл умартан өгүүлэхэд анх бидний Нью-Йоркад буухад угтаж авсан эрдэмтэд, Индианы их сургуулийн профессор Синор, Гомбожав нар (Биднийг угтаж авах гээд алс холын Индианаас ирсэн байсан) урьд АНУ-ын ерөнхийлөгч Рональд Рейганы орж байсан гэх «Анкл Тан»-ы (Тан өвгөний) гуанзанд бидэнд хятад хоолоор оройн зоог барьж, хуучилцагалаа. Хоолны амт шимтээс үзвэл үнэхээр Тан овогтны гэх нь аргагүй.

Ингээд эцэст АНУ-д байх хэдэн хоногт академийн төлөөлөгчид бидний ажил хэрэг түргэн бүтэмжтэй болоход НҮБ-д суугаа манай Бүрэн эрхт төлөөлөгч Нямдоо, Должинсүрэн болон бусад нөхөд ихэд тусласанд гүн талархсанаа тэмдэглэн үлдээе.

Монголын төлөөлөгчид бид хавар-зун халалцах заагийн урин дулаан цаг ирсэн, манай Монголынх шиг нэг цэлмэг сайхан өлзийт өдөр Америкийг орхиж, нутгийнхаа зүг мордлоо.

ЭЛЭГ ДЭВТЭЭСЭН УУЛЗАЛТ

М. Зэнээ

Удам угсаа, гарал үүсэл нэг Монголын ард түмэн уудам дэлхийд тархан суусан нь нэн олон. Тэдний нэлээд хэсэг нь улс гүрний хил хязгаарт таслагдан улмаар салж хөндийрсөн нь ч цөөнгүй. Саяхан болтол нэг монгол туургатанд нэгдэж явсан Өвөр Монголын ард түмэн Хятад улсын харъяанд үлдсэнээс хойш ах дүү, аав, ээж, амраг садан аль олон хүмүүс хилийн наана цаана таслагдан үлдэж, уулзаж учиралгүй нэлээд олон жил өнгөрснийг бид мэднэ.

Улс хоорондын харилцаа хэвийн найртай байхад ах дүү хүмүүс, хэдийгээр өөр өөр улсад амьдарч байсан ч сэтгэлээр өнчирдөггүй, уулзан учирч, элэг дэвтээж явдаг байна. Улс төрийн бодлого эвгүй тийш хандаж, улс хоорондын харилцаа хүйтэн хөндий болоход ард